

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

### КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Коронавируст халдварт /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд доор дурсан агуулгатай хэсэг, заалт, тайлбар нэмсүгэй:

#### 1/3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэг:

“3.3. Монгол Улсын Их Хурал болон Засгийн газрын тогтоолоор тэмдэглэн өнгөрүүлэх шийдвэр гарсан тэмдэглэлт өдөр, баяр ёслолын хүрээнд хийгдэж буй үйл ажиллагаа нь энэхүү хуулийн үйлчлэлд хамаарахгүй.

Тайлбар: Монгол Улсын Их Хурал болон Засгийн газрын тогтоолоор тэмдэглэн өнгөрүүлэх шийдвэр гарсан тэмдэглэлт өдөр, баяр ёслолын хүрээнд хийгдэж байгаа үйл ажиллагаа” гэдэгт Монгол Улсын Их Хурал болон Засгийн газрын тогтоолоор тэмдэглэн өнгөрүүлэх шийдвэр гарсан тэмдэглэлт өдөр, баяр ёслолын хүрээнд хийгдэж буй хурал, цуглаан, биеийн тамирын болон бусад төрлийн уралдаан, тэмцээн, баяр, наадам, урлагийн тоглолтыг ойлгоно.”

#### 2/7 дугаар зүйлийн 7.1.32-7.1.35 дахь заалт:

“7.1.32. коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажилд албан үүргээ гүйцэтгэж байхдаа Коронавирусын халдварт авсан албан хаагч, албан үүргээ гүйцэтгэж байхдаа Коронавирусын халдварт авч нас барсан албан хаагчийн гэр бүлд олгох буцалтгүй тусламжийн асуудлыг шийдвэрлэх;

7.1.33. хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай бараа бүтээгдэхүүн, эм, эмнэлгийн хэрэгсал тоног төхөөрөмжийг улсын хилээр хойшлуулашгүйгээр нэвтрүүлэх арга хэмжээ авах;

7.1.34. цар тахлын үед харилцаа холбоо, мэдээллийн технологи, эрчим хүч, цэвэр ус, хүнс хангамж, шатахуун түгээх газар, төрийн өмчтөн онц чухал болон стратегийн зориулалттай үйл ажиллагаа эрхэлдэг үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагын тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах арга хэмжээ авах.

7.1.35. цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, чиглэлээр албан үүргээ гүйцэтгэж байгаа алба хаагчдын 0-12 хүртэлх насны хүүхдийг хамруулах цэцэрлэгийг халдварт хамгааллын дэглэмийг баримтлан хөл хорионы үед нээн ажиллуулах.”

#### 3/8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалт:

“8.1.9.халдварын тохиолдол, тэдгээрийн хавьтлыг олж тогтоох, илрүүлэх шинжилгээ авах, сорьц цуглуулах, тусгаарлах, хорио цээр, хязгаарлалтын дэглэм сахиулах, хөл хорионд орсон иргэдийг харьяалах оршин суух газарт зорчих үйл ажиллагааг иргэдийн амьдралын наад захын хэрэгцээ, хэрэглээг хязгаарлахгүйгээр удирдан зохион байгуулах.”

#### **4/9 дүгээр зүйлийн 9.20-9.24 дэх хэсэг:**

“9.20.Эрүүгийн, иргэний, зөрчлийн болон захиргааны хэрэг, маргааныг шүүхэд хянан шийдвэрлэх, түүнд талуудыг оролцуулах, хууль зүйн туслалцаа авах, үзүүлэх эрх, үүргийг тодорхойлсон журмыг Улсын Дээд шүүх, Улсын Ерөнхий Прокурор, Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Аivilгатай тэмцэх газар, тагнуулын төв байгууллага хамтран батална.

9.21.Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гадаад улсаас Монгол Улсын иргэдийг татан авах хуваарь, цар тахалтай тэмцэх талаар явуулж буй үйл ажиллагааны талаар шуурхай мэдээлэл өгөх, тусгай үүргийн нислэг болон бусад хэлбэрээр хийгдэж буй татан авалт гэнэт цуцлагдсан үед орох орон, хоол, хүнсгүй болсон иргэдэд наад захын хэрэгцээг хангах мөнгөн тусламж олгох ажлыг зохион байгуулна.

9.22.Халдвар авсан иргэний хөдөлгөөнийг тогтоох зорилгоор иргэн, хуулийн этгээдээс мэдээ, мэдээлэл авах, ашиглах, хадгалах, хянах журмыг Хүний эрхийн Үндэсний Комиссын саналыг харгалзан Улсын ерөнхий прокурор, Тагнуулын ерөнхий газрын болон Цагдаагийн ерөнхий газрын дарга хамтран батална.

9.23.Монгол Улсын мөнгөн тэмдэгтийн нөөцийг бий болгох зорилгоор шинээр үйлдвэрлэсэн мөнгөн тэмдэгтийг улсын хилээр саадгүй нэвтрүүлэх, тээвэрлэлтийн хэвийн нөхцөлийг хангахтай холбоотой шаардлагатай арга хэмжээ авна.

9.24.Цар тахлын үед Засгийн газар, төрийн бусад байгууллага, аж ахуйн нэгжтэй цар тахлын хүрээг тогтоохтой холбоотой тоон мэдээ, мэдээллийг шуурхай харилцан солилцож хамтран ажиллана.”

#### **5/10 дугаар зүйлийн 10.8-10.14 дэх хэсэг:**

“10.8.Энэ хуулийн 10.7-д зааснаар ипотекийн зээлийн төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг хойшлуулж, хойшлуулсан хугацаагаар зээлийн гэрээний хугацааг сунгах тухай зээлдэгчийн хүсэлтийг үндэслэн банкны танилцуулсан ипотекийн зээлийн гэрээнд оруулах нэмэлт өөрчлөлтийн саналыг зээлдэгч хүлээн зөвшөөрснөө энэ хуулийн 10.9-д зааснаар илэрхийлснийг банк хүлээн авснаар талууд ипотекийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсанд тооцно.

10.9.Банк, эрх бүхий хуулийн этгээдээс цахим хэлбэртэй үйлчилгээнд тухайн банк, эрх бүхий хуулийн этгээдэд данстай, санхүүгийн тогтвортой харилцаа үүсгэсэн этгээдийн бүртгэлтэй баталгаат цахим шуудан, эсхүл техникийн хэрэгсэл, програм хангамж, нууцлалын шаардлага хангасан нууц үг, нууц код, тоон гарын үсэг зэргийг ашиглан гаргасан саналыг банк, эрх бүхий хуулийн этгээд хүлээн авсан бол Иргэний хуулийн 42<sup>1</sup> дүгээр зүйл, 196.1-д заасантай адилаар хэлцэл хийсэн, гэрээ байгуулсанд тооцно.

10.10. Цар тахлын үед банкнаас цахим хэлбэрээр ипотекийн зээл болон бусад зээлийн гэрээнд өөрчлөлт оруулахтай холбоотой журмыг Монголбанк батална.

10.11. Энэ хуулийн үйлчлэх хугацаанд гадаад валютын хадгаламжийн гэрээг байгуулсан хугацаанаас үл хамааран банкны нийт гадаад валютын хадгаламжийг Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд заасан албан журмын даатгалд хамруулахгүй бөгөөд мөн хуулийн 8.1, 15.4-т заасан нөхөн төлбөрийг гадаад валютын хадгаламжинд олгохгүй.

10.12. Энэ хуулийн 18.1-т заасан хугацаанд банкнаас харилцагчтай хугацаатай мөнгөн хадгаламжийн гэрээ байгуулах, хадгууллагчтай байгуулсан гэрээний хугацаа дуусгавар болж гэрээний хугацааг сунгахад мөнгөн хадгаламжийн хүүгийн хэмжээ нь банкуудын нийтэд зарласан хугацаатай мөнгөн хадгаламжийн жигнэсэн дундаж хүүгээс хэтрэхгүй байна.

10.13. Санхүүгийн зохицуулах хороо нь эрсдэл үүссэн, зайлшгүй нөхцөл байдлын үед санхүүгийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд тусгайлан шаардлага тавьж, хязгаарлалт хийх.

10.14. Банкны харилцагчдыг валютын ханшийн эрсдэлээс сэргийлэх, ханшийн зөрүүг зохицуулахдаа санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглах, төр, аж ахуйн нэгж, байгууллага харилцан тохиролцсоны үндсэн дээр хэлэлцээр хийх нөхцөлийг бүрдүүлж холбогдох арга хэмжээг авах.”

#### **6/11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг:**

“11.3. Иргэдийн байршил, хөдөлгөөнийг тэмдэглэх, бүртгэх зорилгоор ашиглаж буй аливаа программ болон техник хангамжийн өгөгдлийн санд цугларсан мэдээллийг зөвхөн цар тахалтай тэмцэх үйл ажиллагаанд ашиглах бөгөөд гуравдагч этгээдэд тараахыг хориглоно. Энэхүү үйл ажиллагааг харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлж, хяналт тавина.”

#### **7/11 дүгээр зүйлийн 11.7 дахь хэсэг:**

“11.7. Энэ хуулийн 11.5-д заасан хяналт тавих үйл ажиллагаанд төрийн бусад байгууллагууд дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.”

#### **8/12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсэг:**

“12.5. Цар тахлаар өвчилсөн, эдгэрсэн, халдварт авсан байж болзошгүй болон хавьтад орсон иргэдийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжлох, тэдэнд сэтгэл санааны дарамт учруулж болзошгүй мэдээ, мэдээлэл тараахыг хориглоно.”

#### **9/13 дугаар зүйлийн 13.2.10 дахь заалт:**

“13.2.10. Энэ хуулийн 3.3-т заасан ажиллагааны хүрээнд хийгдэх үйл ажиллагаанд Засгийн газар, Улсын онцгой комиссоос гаргасан заавар, зөвлөмжийг баримтлах;”

#### **10/13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг:**

**“13.4. Цар тахлаар өвчилсөн, эдгэрсэн, халдварт авсан байж болзошгүй болон хавьталаад орсон иргэдийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжлох, тэдэнд сэтгэл санааны дарамт учруулж болзошгүй мэдээ, мэдээлэл тараахыг хориглоно.**

**11/17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг:**

**“17.3. Энэ хуульд заасан үндэслэл, журам, эрх хэмжээний хүрээнд шийдвэр гаргаж, арга хэмжээ авсантай нь холбогдуулан хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд эрх бүхий байгууллага, албан тушаалтанд аливаа хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй.”**

**2 дугаар зүйл.** Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтын “дэмжлэг үзүүлэх” гэсний дараа “, ажилгүйдлийн тэтгэмж олгох” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын “зээл олгох” гэсний дараа “, банкны үнэт цаас худалдан авах” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтын “гэж үзвэл” гэсний дараа “Хүний эрхийн Үндэсний Комисс болон” гэж, 13 дугаар зүйлийн 13.2.1 дэх заалтын “сахин биелүүлэх” гэсний дараа “, мэдээлэл солилцох, хамтран ажиллах” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/10 дугаар зүйлийн 10.4, 10.5 дахь хэсэг:**

**“10.4. Цар тахлын үед банкны хугацаагүй хадгаламж, харилцах дансанд хүү тооцохгүй, тусгай нөхцөлтэй хадгаламжид энгийн хадгаламжийн хүү тооцох бөгөөд Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1-т заасны дагуу Монголбанкнаас зөвшөөрөл олгосон болон 4.4-т зааснаас бусад тохиолдолд иргэн, хуулийн этгээд хоорондын мөнгөн төлбөрийн үүрэг, гүйлгээг гадаад валютаар гүйцэтгэхийг хориглоно.**

**10.5. Эрсдэл бүхий нөхцөлд үүрэг гүйцэтгэж байгаа төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагчид зориулсан түрээслэх, хөлслөх байдлаар өмчлөлд шилжих нөхцөлтэй зээлийн тусгай бүтээгдэхүүн гаргах, буюу уг бүтээгдэхүүнийг санхүүжүүлэх зорилгоор хөлс, түрээсийн орлого, шаардах эрх зэрэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нэрлэсэн үнээр худалдан авна.”**

**2/10 дугаар зүйлийн 10.7 дахь хэсэг:**

**“10.7. Энэ хуулийн 10.8-д заасны дагуу зээлийн төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн үлдэгдэл хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр хойшилуулж, зээлийн гэрээний хугацааг 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл сунгах асуудлыг Засгийн газартай хамтран хэрэгжүүлнэ.”**

**4 дүгээр зүйл.** Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.20 дахь заалтын “хамгаалах байранд” гэснийг “хамгаалах байр, хамтарсан багийн үйл ажиллагаанд” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “тухайн улс дахь өвчлөлийн тархалт, эрсдэл, шууд нислэгийн боломж, бусад нөхцөл байдлыг харгалзан” гэснийг “шуурхай” гэж, 10 дугаар зүйлийн гарчгийн

“болон арилжааны банкнаас” гэснийг “, Санхүүгийн зохицуулах хороо болон банк, санхүүгийн байгууллагаас” гэж, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “зорилгоор урвуулан ашиглахыг” гэснийг “ашиглах, нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээхийг” гэж, мөн зүйлийн 11.3 дахь хэсгийн дугаарыг “11.4” гэж, 11.4 дэх хэсгийн дугаарыг “11.5” гэж, 11.5 дахь хэсгийн дугаарыг “11.6” гэж, 13 дугаар зүйлийн 13.2.10 дахь заалтын дугаарыг “13.2.11” гэж, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “авч болно” гэснийг “авч болох бөгөөд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өдөр тутмын нэн шаардлагатай хэрэгцээг хангахад ашиглагддаг эд хөрөнгө, барилга байгууламжийг дайчлахгүй” гэж, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “хуульд” гэснийг “хууль, Захиргааны ерөнхий хуульд” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.**

Гарын үсэг